БАТЛАВ:

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН

ЗАСАГ ДАРГА.....С.ЦАГААНБААТАР

"НИЙТИЙН ХАЛУУН УСНЫ ГАЗАР"-ын БАРИЛГА БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 07 сарын 21-ны өдөр *Цээл сум*

1. Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар:	Шинэ халуун ус барих ТӨАЦСЗДТГ/20250101037
2. Үндэслэл	Цээл сумын ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдааны 10 тоот тогтоол
3. Байршил	Төв аймгийн Цээл сум, Талын хайрханы 2-р баг
4. Захиалагч	Цээл сумын Засаг даргын тамгын газар
5. Хөрөнгө оруулагч байгууллага	Цээл сумын Засаг даргын тамгын газар-Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
6. Төсөвт өртөг /төгрөг/	Шинэ халуун ус барих-180,000,000 /зуун наян сая төгрөг/
7. Барилгын зураг төсөл, төсөв	Халуун усны барилгын болон дагалдах тоног төхөөрөмжийн хамтаар 180.000,000 /нэг зуун наян сая төгрөг/-өөс илүүгүй байхаар төсөвлөнө.
8. Зорилго, ач холбогдол	Сумын иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахуйн эрүүл мэндийг сайжруулах
9. Зориулалт, хүчин чадал	Нийтийн халуун усны газрын стандарт шаардлагыг хангасан, 4 ширхэг шүршүүр, 1 саун, үсчин гоо сайханы өрөө, ажилчдын өрөө, угаалгын өрөө, ариун цэврийн өрөө, техникийн өрөө, Кофе шоп ажиллуулах өрөө, хувцас угаалгын 3 автомат машин байрлуулах өрөө бүхий байгууламж байна.
10. Нийтийн халуун усанд тавих шаардлага	**<u>Ерөнхий шаардлага:</u>** Хаулуун усны барилга нь мэргэжлийн байгууллагын баталсан зураг төлийн дагуу, батлагдсан төсөвт багтаан баригдаж, "Нийтийн халуун усны үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5163:2002" стандартын шаардлага хангасан байна. Нийтийн халуун усны барилга нь усан хангамж, цахилгаан хангамж, агааржуулалтын систем, халаалтын системтэй, шаардагдах гадна шугам сүлжээнд холбогдсон байна. Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй байх, салхины 25м/с хурдад тэсвэртэй, орчны уур амьсгалын байдал, үйлчилгээний барилга нь байгаль цаг уурын бүсчлэлийн нөхцөлд тохируулан -40 хэмээс +35 хэмээр тооцож зургийг боловсруулж батлуулна. Гал түймрийн аюулаас хамгаалах арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. **<u>Үйлчилгээниы байрны үзүүлэлт:</u>**

	Овор хэмжээ: Халуун усны барилга нь 3 метрээс багагүй өндөртэй, нийтийн халуун усны үйлчилгээний ерөнхий шаардлагыг хангасан, 110м^2-аас багагүй 120м^2-аас ихгүй талбайтай, • Цахилгаан хангамжийн эх үүсгүүртэй (380/220в, 100кВт-с багагүй), • Усан хангамжийн эх үүсгүүр, шийдэлтэй, ойр байрлах гүний худгаас ус дамжуулах хоолойгоор авч хэрэглэнэ. • Бохирын бие даасан шийдэлтэй, бохирыг соруулж цэвэрлэдэг 5 тн-оос дээш багтаамжтай байна. • Хог, хаягдлыг цуглуулах, зайлуулах шийдэлтэй, • Ашиглалт/цаг уурын нөхцөл: Үйлчилгээний барилга нь байгаль цаг уурын бүсчлэлийн нөхцөлд тохируулан -40 хэмээс +35 хэмээр тооцсон байх, • Гадна тохижилт: хашаатай, автомашин болон явган зорчигчийн орц, гарцыг шийдсэн, талбай нь хатуу хучилттай байх, гэрэлтүүлэгтэй байх, • Холбоо, дохиоллын системтэй, • Хяналтын камераар тоноглогдсон байх, • Агааржуулалтын системтэй, • Дотор гэрэлтүүлэг ус нэвтрэхгүй, уур цан цохиж хөлрөхгүй байх, • Барилгын дотор хананд усан дусал, уур үүсдэггүй, цан цохидоггүй, дулаанаас хамаарсан агшилт, тэлэлт явагддаггүй байх • Барилгын дотор хана, шал, тоног төхөөрөмж нь цэвэрлэгээ, үйлчилгээ хийхэд хялбар, гөлгөр, тэгш гадаргуутай байна. • Шал хана нь ус нэвтэрдэггүй, цэвэрлэж халдваргүйжүүлэхэд тохиромжтой, хүчил, шүлт, халуун усанд тэсвэртэй, хагарч, цуурахгүй, халтирч, гулсахгүй материалаар зай завсаргүй, нягт хийгдсэн байх бөгөөд ус чөлөөтэй урсаж, бохир зайлуулах хоолой руу орж байхаар тооцсон байна. • Барилгын хана хоорондын болон хана, шалны хоорондын булан нь нүх сүвгүй, сайтар битүүмжилсэн, цэвэрлэгээг хялбаршуулах зорилгоор хана шалны уулзварыг 2.5 см радиусаар хагас дугуйрсан эсхүл 45-60° налуу гадаргуутай хийсэн байх. • Тааз нь тоос шороо, уур, цан хуримтлагдахааргүй, будаг, шохой нь хуурч унахааргүй, хөгц мөөгөнцөр үүсэхээргүй, цэвэрлэхэд хялбар байдлаар төлөвлөсөн байх. • Цонх нь битүүмжлэл сайтай, нягт хаагддаг, нисдэг шавж орохоос урьдчилан сэргийлж торон хаалттай байна. • Хаалга нь бүрэн хаагддаг, шаардлагатай хэсэгт 2 тийшээ нээж, хаадаг эсхүл өөрөө нээгдэж, хаагддаг автомат мэдрэгчтэй байх.

	• Бохир ус зайлуулах суваг нь цэвэр, бат бөх, ямар ч нөхцөлд ус чөлөөтэй урсахуйц байна. • Үйлдвэрийн барилгын дотор талын ханыг дулаалгаас сайтар тусгаарлаж галын аюулгүй байдлыг хангасан байх, **<u>Халуун усны байрны үндсэн өрөө:</u>** • Шүршүүрийн өрөө /4 ширхэг/ • Сауны өрөө /1 ширхэг/ • Угаалгын өрөө /3 ширхэг автомат угаалгын машин байрлуулахуйц хэмжээтэй/ • Техникийн өрөө (цэвэр усны нөөцийн сав, ус халаах бойлуур, цахилгааны шийд зэрэг байрлана.) • Ажилчдын өрөө • Хувцас солих өрөө • Ариун цэврийн өрөө • Кофе шоп ажиллуулах өрөө • Үсчин гоо сайханы өрөө гэсэн өрөө, тасалгаатай байх ба эдгээр өрөө тасалгааг стандартын шаардлагын дагуу тохижуулсан байна.
11. Халуун усны газрын тоног төхөөрөмж	• Автомат угаалгын машин /15кг даацтай 1 ширхэг, 10 кг даацтай 2 ширхэг/ • Бойлуур /ялтсан, 4 шүршүүрийн өрөөг хангахуйц хүчин чадалтай/ • Шүршүүр • Холигч • Суултуур • Хатаагч • Сауны өрөөний тоног төхөөрөмж /тогоор халдаг зуух, сандал гэх мэт/ • Бусад
12. Дагалдах хэрэгсэл	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас (Ажлын цамц, өмд, малгай, амны хаалт, усны гутал, хормогчийн иж бүрдлээр тооцох) Хувцасны шүүгээ, өлгүүр
13. Оффис, ариун цэврийн болон ажилчдын өрөөний тавилга, хэрэгсэл	Үйлчилгээний хүчин чадалтай уялдуулан талбайг тооцож, тохижуулах
14. Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Барилгын тухай хууль; - "Нийтийн халуун усны үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5163:2002" стандарт - Бусад хууль тогтоомж; <u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u> <u>Норм норматив, стандарт:</u> - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм ба дүрэм /БНбД 21.02.02/, /БНбД 31-02-02/ бусад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх - 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил /БД 11-106-08/; - Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт

	- Онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжтой авто машин нэвтрэх боломжийг хангаж төлөвлөх			
15. Барилгын үндсэн бүтээц	Инженер геологийн судалгаа		Инженер геологийн судалгааны дүгнэлтийг шинээр хийнэ.	
	Даацын үндсэн бүтээц:	Суурь:	а.	Цутгамал төмөр бетон бүтээцтэй төлөвлөх ба барилгын норм ба дүрмийн хүрээнд зураг төслөөр төлөвлөнө.
		Гадна хана:	а.	Ханын 2,4м өндөр тоосго, дулаан блок эсвэл бетон бүтэцтэй,
			Ханын дулаалга	Эрдэс хөвөн дулаалга, металл фасад өнгөлгөө, зураг төслөөр норм, дүрмийн хүрээнд төлөвлөнө.
		Хучилт:	а.	Төмөр бетон, зураг төслөөр норм, дүрмийн хүрээнд төлөвлөнө.
		Дээвэр:	а	Шувуун нуруун дээвэртэй төлөвлөнө.
16. Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр /дулаан, усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан, холбоо, инженерийн хангамж/	Цахилгаан хангамж, Дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдох ба хангагч байгууллага, сумын ЗДТГ-аас техникийн нөхцөл авна. Хажууд байрлах нэгдсэн халаалтын АНУ сервис ХХК-аас халаалтаа шийднэ. Цэвэр усан хангамж, ариутгах татуургын бие даасан сүлжээнд холбох ба ЗДТГ-аас техникийн нөхцөл авна. Хамгийн ойр байрлах гүний худгаас шугам хоолойгоор усан хангамжаа авна. Бохирын цооног 5тн-оос багагүй багтаамжтай байх бөгөөд соруулах зориулалтай байна.			
17. Зураг төсөв	Тендерт оролцогч өгөгдсөн даалгаврын дагуу зураг төсвөө боловсруулж ирүүлнэ.			
18. Галын аюулгүй байдлын нөхцөл	Төлөвлөж буй барилга байгууламжийн зай хэмжээг галын болон бусад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх			
19. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл	Шаардлагагүй.			
20. Эдийн засгийн тооцоо	Төсвийг эстиматор про 21 программаар хийсэн байна.			
21. Онцгой нөхцөл	- Монгол Улсын хууль, Барилгын норм ба дүрмийг баримталсан байх. - Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн аюулгүй ажиллагаанд тавигдах олон улсын болон Монгол Улсын холбогдох стандартын шаардлага, норм, дүрмийг баримталсан байх.			

Боловсруулсан: Засаг даргын орлогч Д.Ууганбаяр